

Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Санхүүжилт ба Зөвлөх Үйлчилгээ

Зорилтоо амжилт болгох нь. *Бид хэрхэн хийхийг мэднэ.*

Энэхүү хөтөлбөрийг ЕСБХБ болон Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Санхүүгийн
Санаачилга (We-Fi)-аас санхүүжүүлэв






Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд ажлын байр бий болгож эдийн засгийн өсөлтийг удирдахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг гэдгийг бид мэддэг. Бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд тэгш боломж олгох явдал нь зөвхөн жендерийн бус эдийн засгийн тэргүүн зэргийн асуудал гэдэгт бид хатуу итгэдэг. Тийм учраас манай үйл ажиллагаа хэрэгжиж буй улс орнуудад эмэгтэйчүүд бизнес эрхлэх үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцох, тэднийг бизнесээ амжилттай эрхлэхэд бид дэмжлэг үзүүлэн ажилладаг.

Бизнесээ өсгөмөөр байна уу? Бид хэрхэн хийхийг мэднэ.

Бид танд стратеги, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, байгууллагын удирдлагын ур чадвараа хөгжүүлэх, маркетингийн сүүлийн үеийн арга хэрэгслийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх, ба дэвшилтэт технологи нэвтрүүлж, шилдэг туршлагаас олж авахад тусалж чадна. Мөн Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны нэг хэсэг болохын хувьд, бид бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээс гадна, таны бизнесийн өсөлтөнд шаардлагатай санхүүжилтийг олоход танд тусалж чадна. Манай Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүд хөтөлбөрүүд нь тантай ижил бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдэд гаргасан

санаачилгаа урт хугацааны бизнес болгож хувиргах мэдлэг туршлага олгох зорилгоор бүтээгдсэн юм.

Бид бизнестээ амжилт гаргах гэсэн эмэгтэйчүүдэд туслаад арав гаруй жил болж байна. 2010 оноос хойш, бид төслүүдээрээ дамжуулан өөрсдийн ажилладаг 25 орны ойролцоогоор 1,600 эмэгтэй бизнес эрхлэгчдэд тусалсан. Бидний дэмжлэгтэйгээр эмэгтэй удирдлагатай бизнесүүд амжилттай ажиллан зарим тохиолдолд эрэгтэй удирдлагатай бизнесээс илүү ололт амжилт гаргаж байв.



Бид Хмельницкийгийн Хотын Анхны Эмийн Үйлдвэр, 97% эмэгтэй өмчлөгчтэй, бараг 90% нь эмэгтэй ажиллагсадтай компанид, нийт 13 хэлтэстээ чанарын удирдлагын систем нэвтрүүлж, ISO сертификат авахад нь тусалсан. Чанарыг баталгаажуулж чадах болсноор, төсөл дууссаны дараах нэг жилийн дотор, Хмельницкийгийн Эмийн Үйлдвэрийн үйлчлүүлэгчдийн тоо 16%-иар нэмэгдэж, орлого нь 67%-иар нэмэгдсэн, ба 4 шинэ салбар нээж, 15 шинэ ажилтантай болсон.

Бидэнтэй хамтран ажилласнаар:

Бидэнтэй хамтран ажилласнаар:

- эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн 83 хувь нь орлогоо дунджаар 28 хувиар – нэмэгдүүлдэг ба ажлын бүтээмжээ дунджаар 16 хувиар сайжруулдаг
- Эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн 57 хувь нь олон шинэ ажлын байрыг – эмэгтэйчүүдэд голдуу бий болгодог, ба ажиллагсдынхаа тоог дунджаар 8 хувиар нэмэгдүүлдэг
- Эмэгтэй удирдлагатай бизнесүүдийн 14 хувь нь өсөлтөө ханган ажиллахын тулд гадны санхүүжилт олж авсан байдаг.

Бидний санал болгодог үйлчилгээ

Бид эмэгтэйчүүдэд боломжуудаа нээн илрүүлэх, ур чадвараа хөгжүүлэхэд нь туслахын тулд шаргуу ажилладаг ба бизнес дэх эмэгтэйчүүдийн оролцоог хөхүүлэн дэмждэг.

Бизнес эрхлэх ур чадварыг сайжруулах сургалт

Амжилттай бизнестэй болоход сайхан санаа эсвэл гоц авьяасаас илүү олон зүйл хэрэгтэй байдаг. Бид эмэгтэйчүүдэд бизнесийн төлөвлөлт, онлайн маркетинг, санхүүгийн удирдлага ба Мэдээлэл харилцааны технологийг бизнест ашиглах зэрэг бизнес эрхлэхэд зайлшгүй хэрэгтэй ур чадваруудыг хөгжүүлэх бизнесийн практик сургалтуудыг санал болгодог. Манлайлах ур чадвараа хөгжүүлэхээс эхлээд бизнесийн гүйлгээ ухаанаа гүнзгийрүүлэх хүртэл, танд амжилт гаргахад хэрэгтэй бүх ур чадваруудад бид сургах боломжтой.

Бизнесийн зөвлөх үйлчилгээ

Бид компаниудад вэбсайт хөгжүүлэх, эсвэл ISO стандартын шаардлагад нийцсэн чанарын удирдлагын систем нэвтрүүлэх технологийн мэдлэг зэрэг ноу-хау олж

авахад нь туслах төрөл бүрийн төслүүдийг хэрэгжүүлдэг.

Эдгээр нь ихэвчлэн дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажиллах замаар хэрэгждэг бөгөөд ихэнхдээ дөрвөөс зургаан сар үргэлжилдэг. Зөвлөх үйлчилгээний төрлийн хувьд дараах чиглэлүүдийг хамардаг:

- Стратеги
- Маркетинг
- Зохион байгуулалт
- Үйл ажиллагаа
- Мэдээллийн технологи
- Инженерийн шийдэл
- Чанарын удирдлага
- Ня-бо бүртгэл ба санхүүгийн тайлан
- Эрчим хүч/нөөцийн үр ашигт байдал
- Байгаль орчны менежмент

Бизнес коучинг

Бизнесийн төлөвлөгөөтэй байх нь сайн эхлэл, гэхдээ энэ нь ихэвчлэн хангалтгүй байдаг. Бид таны бизнесийн чадавхыг итгэлтэй гэж үзвэл дотоодын бэлтгэгдсэн бизнес коуч (coach) гаргаж өгөх ба тус коуч танд, жилийн турш, тодорхой асуудлууд гарч ирэх бүрт яаж шийдэх талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэн, танд бизнес төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлж дуусгахад туслах юм.

Салбарын мэдлэг

Олон улсад өрсөлдөхөөр эсвэл хөрөнгө оруулалт татахаар зорьж буй компаниудын хувьд, бидэнд ижил салбарт 15-аас дээш жил дээд түвшний удирдлагын ажлын туршлагатай олон улсын зөвлөхтэй ажиллах боломж байна. Энэ хүн танай компанийг илүү чадвартай болоход болон өсөлтийн найдвартай стратеги боловсруулахад туслахын тулд өөрийн ноу-хауг шууд тантай болон танай удирдлагын багтай хуваалцах замаар ажиллах юм.

Санхүүжилт олох

Санхүүжилт олж авах нь жижиг ба дунд хэмжээний бизнесүүдийн хувьд хамгийн том бэрхшээлүүдийн нэг байдаг. Эмэгтэй бизнес эрхлэгчдэд бизнесээ хөгжүүлэхэд тэдэнд шаардлагатай санхүүжилт олоход нь туслахын тулд, бид эмэгтэй удирдлагатай бизнесүүдэд зориулсан бүтээгдэхүүн санал болгох тал дээр орон нутгийн хэд хэдэн арилжааны банкуудтай хамтарч ажилладаг. Монгол улсад бидэнтэй ажилладаг банкуудын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл, манай вэбсайт руу дараах хаягаар орж үзээрэй www.ebrd.com/womeninbusiness .

Бид түүнчлэн бизнес төлөвлөгөө гаргах, ТЭЗҮ боловсруулах эсвэл данс бүртгэлийг олон улсын жишигт хүргэн танд хөрөнгө оруулалт татахад тусалж чадна. Хөрөнгө оруулалтын дараа, бид харилцагчид даа зорилгодоо хүрэх, хөрөнгө зарцуулалтын

зөв шийдвэрүүдийг гаргах, компанийн засаглалаа сайжруулах болон өсөлтөө удирдахад нь дэмжлэг үзүүлдэг. Бид зөвлөх үйлчилгээний төслүүдийн зардлын томоохон хэсгийг хариуцдаг, ба манай түнш санхүүгийн байгууллагуудаас зээл авсан тохиолдолд тэтгэлгийн хувь нэмэгддэг.

Зөвлөгч (mentor)

Зөвлөх үйлчилгээний түншлэлээрээ дамжуулан, бид таныг манай глобал сүлжээний туршлагатай бизнес эрхлэгчтэй холбож өгөх боломжтой. Мэдлэг, туршлагын арвин их сантай зөвлөгч нь танд хувийн үзэл бодлоо өөрчилж, бэрхшээлийг даван туулахад тусална. Манай менторинг хөтөлбөрүүд нь бизнест амжилт гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг удирдах ба манлайлах чадваруудыг хөгжүүлдэг .



Азра Атажик-Катович шинэлэг онлайн бизнесээ 2005 онд байгуулсан. Уг бизнес нь Босни Герцеговинагийн хамгийн алдартай бизнесийн портал вэбсайт болсон ба бизнесүүд тус

вэбсайтнаас бүс нутгийн төрийн худалдан авалтын боломжуудын талаарх мэдээллийг авдаг. Бид тус компанийг олон улс даяар төрийн тендерүүдийг ангилдаг CPV код нэвтрүүлсэн улсынхаа анхны компани болоход нь тусалсан. Ангилал сайн байна гэдэг нь eCarija-гийн захиалагчид хэрэгтэй мэдээллээ илүү амархан хайж чадна гэсэн үг. Энэ нь компанид шинэ шинэ худалдан авагчид авчирсан ба компанийг байнга өрсөлдөөний эхэнд байлгадаг. Хатагтай Атажик-Катович нь бас манай хөтөлбөрийн зөвлөгч, ба бусадтай өөрийн мэдлэг туршлагыг хуваалцдаг.

Таныг амжилтад хүргэе. *Бид хэрхэн хийхийг мэднэ.*

1. Эмэгтэй бизнес эрхлэгч үү?

Бид бараг салбар болгоны эмэгтэй удирдлагатай бизнесүүд, түүнээс гадна бизнесийн гайхалтай санаа олсон эмэгтэйчүүдтэй ажилладаг. Хөтөлбөрт хамрагдахын тулд, компанийн үйл ажиллагааны ерөнхий удирдлага нь эмэгтэй хүн байх шаардлагатай. Бидэнтэй хамтран ажиллахад тавигдах шалгууруудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай багтай холбоо бариарай эсвэл www.ebrd.com/womeninbusiness хаягаар манай вэбсайт руу орж үзээрэй.

2. Бидэнтэй холбоо бариарай.

Та бидэнтэй утсаар эсвэл имэйлээр холбоо барьж болно, эсвэл манай оффис дээр цаг авч ирээд манай ажилтнуудын нэгтэй ярилцаж болно. Та манай холбоо барих мэдээллийг сүүлийн хуудаснаас харах боломжтой.

3. Бизнесийн хэрэгцээгээ тодорхойлоорой

Бид зөвлөх үйлчилгээнээс санхүүжилт хүртэл танд юу хэрэгтэйг ойлгохын тулд таны бизнес эсвэл бизнесийн санааг бүх талаас нь судалж ажилладаг.

4. Дараагийн ажлаа төлөвлөөрэй.

Та манай ноу-хауг олон янзын аргаар өөртөө ашиглаж болно. Хөтөлбөрийн аль хэсэг нь илүү таны сонирхлыг татаж байгааг бидэнд хэлээрэй.

Манай орон нутгийн эсвэл олон улсын мэргэжилтнүүдийн нэгнийх нь бизнесийн зөвлөх үйлчилгээ ч байж болно, манай сургалт курсуудын нэгэнд оролцох, эсвэл зөвлөгч ба зааварлагчийн аль нэгнээс нь дэмжлэг авах гээд аль нь ч байж болно. Бид эдгээр үйл ажиллагаануудад зардал хуваах зарчмыг санал болгодог.

5. Бидэнтэй хамтран ажиллах.

Бид олон жил ажилласан ажлын туршлагаа хэрэглэн танд тохирсон дэмжлэгийг үзүүлэх явдлыг баталгаажуулдаг. Манай сургалтын курсуудээс эхлээд манай зөвлөх үйлчилгээнүүд хүртэл, бүгд танд тулгараад буй бэрхшээлийг шийдэхэд зориулан хийгддэг. Мөн, хэрэв таны бизнесийн өсөлтөд санхүүжилт хэрэгтэй гэж үзэж байгаа бол, бид манай түнш банкнуудын нэгийг танд санал болгож болно.

6. Амжилт.

Төсөл эсвэл сургалт дуусахаар бидний дэмжлэг зогсоно гэсэн үг биш. Төсөл дууссаны дараа, үргэлжлүүлээд юу хийж болох талаар бодож олохын тулд бид тантай хамт сууж ярилцдаг. Энэ нь шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ санхүүжилт олох, таны бизнесийн өөр бусад чиглэлд зөвлөх ажиллуулах эсвэл та өөрөө таны ижил бизнес эрхлэгчдэд тусалдаг зөвлөгч болох ч байж болно. Бид нэг жилийн дараа буцаж ирж таны амжилтын талаар ярилцах болно.

2. Бидэнтэй холбоо бариарай

1. Эмэгтэй бизнес эрхлэгч үү?



3. Бизнесийн хэрэгцээгээ тодорхойлоорой



6. Амжилт



5. Бидэнтэй хамт ажиллаарай



4. Дараагийн ажлаа төлөвлөөрэй

.....

Жижиг Дунд Бизнесийг Дэмжих Баг
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк

М-Си-Эс Плаза, 3 давхар, Сөүлийн гудамж 4А, Улаанбаатар 14251

Утас: 976-11-319278 / 317974 Факс: 976-11-315844

Э-шуудан: knowhowmongolia@ebrd.com

Е knowhow@ebrd.com W ebrd.com/womeninbusiness

.....